



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/26

Хэрлэн сум

Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнтэй холбогдуулан зөрчил арилгуулах талаар авах арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 9, 46, 2021 оны 278, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолууд, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арванзургаадугаар хуралдааны 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүн”-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор илэрсэн бүртгэлд тусгагдаагүй эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлдээ тусгах, маргаантай болон дутагдуулсан хөрөнгийн асуудлыг хууль хяналтын зохих байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх, төлбөрийг барагдуулах тал дээр анхаарч ажиллах, газар, тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлөө 2023 оны 1 дүгээр улиралд багтаан арилгах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга болон холбогдох байгууллагын дарга, эрхлэгч, захирлуудад үүрэг болгосугай.

2.Газрын хэмжээ талбай зөрүүтэй, үл хөдлөх хөрөнгийн доод эзэмшлийн газрыг бүртгэлд аваагүй, газрын гэрчилгээ шинэчлээгүй (QR кодтой) гэрчилгээ аваагүй хуулийн этгээдийн зөрчлүүдийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан арилгахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Хишигбаяр), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Төрхүү), Тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан арилгуулахыг Автотээврийн төвийн дарга (Ц.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ